



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/40

Чингис хот

Зарим байгууллагын үйл ажиллагааг
дэмжих тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалтууд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 180 дугаар тушаал, аймгийн Онцгой комиссын №02 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн сурагчдад танхимын сургалт эхлэх хүртэл хугацаанд давтлагыг халдвараас урьдчилан сэргийлж, холбогдох дүрэм, журам тавигдах шаардлагыг хэрэгжүүлж хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл урлагын газар /С.Мөнхцэцэг/, Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, Сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

2. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй жолооны курсийг коронавирус халдвар /COVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэм барьж сургалт зохион байгуулахыг Цагдаагийн газар /Б.Батсайхан/, хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т тус тус үүрэг болгосугай.

3. Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дэргэдэх ахмадын сувиллын үйл ажиллагааг халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлэн ажиллахыг Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар /С.Эрдэнэжаргал/, Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т тус тус үүрэг болгосугай.

4. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор “Нямодо трейд” ХХК-ны уурын зуухны хэвийн үйл ажиллагааг хангуулахад шаардагдах 10 000 000 /арван сая/ төгрөгийг аймгийн Засаг даргын гамшгаас хамгаалах сангаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010126